



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/138

Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 233 дугаар тогтоолын 4.1.2 дахь заалт, Монгол улсын Шадар сайдын 2017 оны “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны дотор батлуулан хэрэгжүүлж ажиллахыг орон тооны бус зөвлөлийн дарга / М.Ганзориг /-т даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Орон тооны бус зөвлөл байгуулах тухай тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/133 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



080624

Сайдын 2018 он 04 сарын 09 ны
өдрийн 4/58 дугаар тушаалын
хавсралт.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг
зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн
бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:

Хуулийн хэлтсийн дарга / М.Ганзориг /

Нарийн бичгийн дарга:

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн / Д.Хэрлэнчимэг /

Гишүүд:

Сайдын зөвлөх / Б.Бямбадорж /

Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга / Д.Нарантуяа /

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга / Д.Өнөболд /

Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга / М.Уранчимэг /

Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн дарга
/ Д.Нарангэрэл /

Төрийн захиргаа удирдлагын газрын эм хангамжийн байгууллагын тусгай
зөвшөөрлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн / Б.Болорчимэг /

Эмнэлгийн тусламжийн газрын эмнэлгийн яаралтай тусламж, сувилахуйн
тусламж үйлчилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
/ С.Алтанбагана /

Бодлого, төлөвлөлтийн газрын төр, хувийн хэвшлийн түншлэл, тусгай
зөвшөөрлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн / Б.Энхцэцэг /

Хяналт - шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын Эрүүл мэндийн
байгууллагын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн / Б.Хишигбаяр /

Нийгмийн эрүүл мэндийн газрын халдварт бус өвчин, осол гэмтлийн
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн / Т.Энхзаяа /

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэрэглэгчдийн эрх
ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн / Б.Батбаатар зөвшилцсөнөөр /

Эмийн холбооны гүйцэтгэх захирал / Н.Мөнгөнзагас зөвшилцсөнөөр /